



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Дадлага, сургуульд оролцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын бүтцийн нэгжийн дунд 2019 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдах марш тусгай бэлтгэлийн дадлага, сургуульд дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах ангиуд болон нийслэлийн Аврах анги-105-ын баг тамирчдыг бүрэн хамруулсугай.

2. Сургууль, дадлагад шаардагдах зардлын тооцоог хавсралт ёсоор баталсугай.

3. Шаардагдах 7.500.000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.


4. Дадлага, сургуулийг мэргэжлийн удирдлагаар ханган, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу зохион байгуулан, дүнг 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ирүүлэхийг нийслэлийн Аврах анги-105, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн  
А/13 дугаар тушаалын хавсралт



СУРГАЛТАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| №        | Дүүрэг  | Анги салбар                              | Мөнгөн дүн /төгрөг/ |
|----------|---|--|---------------------|
| 1        | Нийслийн Онцгой байдлын газар                 | Нийслэлийн Аврах анги-105                | 500.000             |
| 2        | Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс      | Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги | 500.000             |
| 3        | Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс        | Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр анги | 500.000             |
|          |   | Гал түймэр унтраах, аврах 30 дугаар анги | 500.000             |
|          |   | Гал түймэр унтраах, аврах 65 дугаар анги | 500.000             |
| 4        | Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Гал түймэр унтраах, аврах 11 дүгээр анги | 500.000             |
|          |   | Гал түймэр унтраах, аврах 26 дугаар анги | 500.000             |
|          |   | Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр анги | 500.000             |
| 5        | Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс       | Гал түймэр унтраах, аврах 35 дугаар анги | 500.000             |
|          |   | Гал түймэр унтраах, аврах 63 дугаар анги | 500.000             |
| 6        | Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс        | Гал түймэр унтраах, аврах 18 дугаар анги | 500.000             |
| 7        | Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс     | Гал түймэр унтраах, аврах 80 дугаар анги | 500.000             |
| 8        | Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс       | Гал түймэр унтраах, аврах 64 дүгээр анги | 500.000             |
| 9        | Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс         | Гал түймэр унтраах, аврах 28 дугаар анги | 500.000             |
| 10       | Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс      | Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр анги | 500.000             |
| Нийт дүн |   |  | 7.500.000           |

---oOo---